



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"ЭРДЭНЭТ-БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/96/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Л.Нямтөмөр
Утас: 261885 Цахим хаяг: nyamtumurl@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн: Мишээл-Од Аудит ХХК
Захирал Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл	15
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
8. Аудитын илрүүлэлт	16
8.1 Залруулсан алдаа	16
8.2 Төлбөрийн акт	17
8.3 Албан шаардлага	17
8.4 Зөвлөмж	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХАЦЭХ	Худалдан авсан цахилгаан эрчим хүч
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ЭХТ	Эрчим хүчний төсөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭТ-БУЛГАНЫ ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ В.АДЪЯА
ТАНАА

2022.03.15 № 07/565
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Засгийн газрын 2020 оны “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолд цахилгаан эрчим хүчний төлбөрийг төрөөс хөнгөлөлт үзүүлэхдээ өмнөх үеийн мөн үеийн хэрэглээнээс хэтрүүлэхгүй гэж заасан боловч Эрчим хүчний сайдын 2021 оны А/01 дүгээр тушаалаар “Шинээр холбогдсон, халаалтаа цахилгаанаар бүрэн шийдсэн, ижил төстэй хэрэглэгчийн өмнөх оны мөн үеийн дунджаас бага хэрэглээтэй байсан, гэрээний эзэмшигч өөрчлөгдсөн хэрэглэгчийн төрөөс хариуцах төлбөрийн хэмжээг тухайн хэрэглэгчийн гүйцэтгэлийг харгалзан ижил төстэй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын дундаж хэрэглээтэй дүйцүүлж тогтооно” гэсэн заалтын дагуу 2020 онд 31,396.3 сая төгрөгийн эрчим хүч хэрэглэж байсан хэрэглэгчид 2021 оны хөнгөлөлтөд хамрагдан 33,060.7 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлж 1,664.4 сая төгрөгийн хөнгөлөлтийг илүү эдэлсэн байна. Үүнээс аж ахуй нэгж байгууллагын хэрэглээ 981.8 сая төгрөгөөр буурч, ахуйн хэрэглэгчийн хэрэглээ 2,646.3 сая төгрөгөөр өссөн байна.

Ахуйн хэрэглэгчийн хэрэглээний өсөлт 2,646.3 сая төгрөгийн хөнгөлөлтөөс шинээр нэмэгдсэн хэрэглэгчид 768.0 сая төгрөгийн цахилгаан эрчим хүч хэрэглэсэн тул өмнөх оны мөн үеэс 1,878.3 сая төгрөгөөр илүү дүнгээр хөнгөлөлтөд хамрагдсан байна.

Үүнээс дүгнэхэд цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтийг өмнөх оны мөн үетэй шууд харьцуулахгүйгээр өмнөх оны хэрэглээнээс их хэрэглээ гарсан хэрэглэгчдийн хөнгөлөлтийг ижил төстэй хэрэглэгчийн хэрэглээтэй дүйцүүлж хөнгөлөлт эдлүүлснээр хэрэглэгчдэд төлөвлөснөөс илүү хөнгөлөлт эдлүүлсэн, 12 дугаар сарын санхүүжилтийг олгоогүйгээс компанийн авлага өсөж, төлбөрийн чадвар буурсан, хэрэглэгчдийн цахилгааны хэрэглээг хэмнэлтгүй зарцуулах, төлбөрөө хугацаанд нь төлөхгүй байх хандлагыг нэмэгдүүлсэн зэргээр сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Дэлхийн банкны санхүүжилтээр эрчим хүчний цахилгаан хангамжийг сайжруулах, түгээх компанийн алдагдлыг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах зорилгоор “Эрчим хүчний төсөл-2” нь 2018 оноос эхэлж 16,187.0 сая ам.долларын санхүүжилтийн ажлыг гүйцэтгэн 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хэрэгжихээр байна. 2021 оны байдлаар гүйцэтгэлийг үнэлэн олгосон санхүүжилт нь 7,440.0 сая ам.долларын гүйцэтгэлтэй буюу ажлын гүйцэтгэл 45.9 орчим хувийн биелэлттэй байгаа нь төсөл хугацаандаа хэрэгжих боломжгүй байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна гэж үзлээ.

Бусад асуудал

Эрчим хүчний Сайдын 2021 оны А/14 дүгээр тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 261,939.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 264,337.0 сая төгрөгөөр, алдагдлыг 2,398.0 сая төгрөг байхаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 269,870.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 270,572.9 сая төгрөгийн зардал гарган, 702.1 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Зорилтот түвшнийг батлахдаа үндсэн хөрөнгийн элэгдлийг бодит байдлаас багаар баталдгаас компанийн зардал хэтэрч, алдагдал нэмэгдэхэд нөлөөлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр 1176 арга хэмжээ төлөвлөснөөс 1079 ажлыг хэрэгжүүлж, хэрэгжилт 91.7 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,355,014,372.46	1,483,954,128.55
1.1.2	Дансны авлага	15,271,295,791.12	23,523,539,458.65
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	219,971,437.60	91,531,368.40
1.1.4	Бусад авлага	74,000,038.48	28,470,624.44
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	2,271,797,482.28	3,808,700,311.24
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,320,694,297.49	2,889,952,242.08
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10	Эргэлтийн хөрөнгийн дүн	21,512,773,419.43	31,826,148,133.36
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	134,617,242,582.91	140,050,918,184.09
1.2.2	Биет бус хөрөнгө	3,017,491,781.16	2,989,749,190.09
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	218,130,348.46	980,130,838.13
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	137,852,864,712.53	144,020,798,212.31
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	159,365,638,131.96	175,846,946,345.67
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	13,496,662,161.40	21,353,583,324.64
2.1.1.2	Цалингийн өглөг	3,759,334.10	1,741,597.16
2.1.1.3	Татварын өр	83,236,801.01	218,061,463.03
2.1.1.4	НДШ – ийн өглөг	208,718.36	4,358,082.96
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг	108,457,479.72	159,782,725.22
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	707,351,337.16	309,240,423.72
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/	23,640,433.94	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		90,274,515.16
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12	Богино хугацаат өр төлбөрийн дүн	14,423,316,265.69	22,137,042,131.89
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	12,190,266,352.09	21,227,329,712.71
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		23,488,395.19
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	368,995,247.11	5,850,137,732.12
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	9,337,702,827.68	3,082,005,912.60
2.1.2.5	Урт хугацаат өр төлбөрийн дүн	21,896,964,426.88	30,182,961,752.62
2.2	Өр төлбөрийн нийт дүн	36,320,280,692.57	52,320,003,884.51
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	41,896,959,300.00	48,120,648,100.00
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		

2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	82,732,033,962.57	82,772,079,052.45
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,812,142,660.00	2,812,142,660.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(4,395,778,483.18)	(10,177,927,351.29)
2.3.10	Эздийн өмчийн дүн	123,045,357,439.39	123,526,942,461.16
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	159,365,638,131.96	175,846,946,345.67

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	254,963,160,288.01	269,396,897,140.99
2	Борлуулалтын өртөг	243,227,839,523.59	257,391,358,190.26
3	Нийт ашиг(алдагдал)	11,735,320,764.42	12,005,538,950.73
4	Түрээсийн орлого	21,600,000.00	21,600,000.00
5	Хүүний орлого	60,014,331.68	
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	790,025,988.34	449,718,079.02
9	Борлуулалт, маркетингийн зардал	4,575,372,352.45	4,540,894,655.89
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,042,805,690.96	8,107,794,214.37
11	Санхүүгийн зардал	46,684,719.92	131,662,163.87
12	Бусад зардал	557,238,283.35	395,592,611.42
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(464,553,103.13)	(366,151.00)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(32,884,235.84)	(2,693,611.39)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(1,112,577,301.21)	(702,146,378.19)
19	Орлогын татварын зардал	6,001,433.17	196,256,391.01
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,118,578,734.38)	(898,402,769.20)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,118,578,734.38)	(898,402,769.20)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	41,896,959,300.00	82,711,275,017.35	2,574,667,240.00	(3,138,892,380.30)	124,044,009,177.05
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(118,628,264.49)	(118,628,264.49)
Залруулсан үлдэгдэл	41,896,959,300.00	82,711,275,017.35	2,574,667,240.00	(3,257,520,644.79)	123,925,380,912.56
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				(1,118,578,734.39)	(1,118,578,734.39)
Бусад дэлгэрэнгүй орлого		20,758,945.22			20,758,945.22
Өмчид гарсан өөрчлөлт			237,475,420.00		237,475,420.00
Зарласан ногдол ашиг				19,679,104.00	19,679,104.00
2020 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	41,896,959,300.00	82,732,033,962.57	2,812,142,660.00	(4,395,778,483.18)	123,045,357,439.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(4,883,746,098.91)	(4,883,746,098.91)
Залруулсан үлдэгдэл	41,896,959,300.00	82,732,033,962.57	2,812,142,660.00	(9,279,524,582.09)	118,161,611,340.48
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-	(898,402,769.20)	(898,402,769.20)
Бусад дэлгэрэнгүй орлого		40,045,089.88			40,045,089.88
Өмчид гарсан өөрчлөлт	6,223,688,800.00				6,223,688,800.00
2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	48,120,648,100.00	82,772,079,052.45	2,812,142,660.00	(10,177,927,351.29)	123,526,942,461.16

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	254,590,020,656.22	287,938,585,273.23
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	252,201,022,248.90	260,908,773,913.91
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		25,867,476,496.54
	Бусад мөнгөн орлого	2,388,998,407.32	1,162,334,862.78
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	250,694,346,269.84	285,738,681,564.14
	Ажиллагчдад төлсөн	9,226,754,435.00	9,555,427,018.72
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,039,122,099.50	2,996,757,617.70
	Бараа материал худалдан авахад төлсөн	230,364,757,036.97	265,756,884,265.97
	Ашиглалтын зардалд төлсөн	94,846,888.53	106,607,988.78
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,191,966,869.08	1,261,117,132.66
	Хүүний төлбөрт төлсөн	435,365,566.57	606,386,405.71
	Татварын байгууллагад төлсөн	2,943,897,731.86	2,986,006,233.91
	Даатгалын төлбөрт төлсөн	20,496,023.00	20,602,705.00
	Бусад мөнгөн зарлага	3,377,139,619.33	2,448,892,195.69
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,895,674,386.38	2,199,903,709.09
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	77,670,808.34	3,300,000.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	17,660,000.00	3,300,000.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүний орлого	60,010,808.34	
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,271,568,719.05	2,072,711,267.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,139,208,719.05	2,052,811,267.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	132,360,000.00	19,900,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,193,897,910.71)	(2,069,411,267.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	22,784,476.54	1,552,686.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,105,372.54	1,552,686.00

	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг	19,679,104.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(22,784,476.54)	(1,552,686.00)
4	Валютын ханшийн зөрүү	39,113.41	
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(320,968,887.46)	128,939,756.09
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,675,983,259.92	1,355,014,372.46
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,355,014,372.46	1,483,954,128.55

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлт		хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
					төлөвлөг өө	гүйцэтгэл		
1	Худалдаж авсан цахилгаан		сая.кВтц	1,181.9	1,226.4	1,256.5	30.1	2.5%
2	ЦЭХ-ний алдагдал	хувиар	%	3.56%	3.28%	3.77%	0.49%	
		биетээр	сая.кВтц	42.1	40.2	47.4	7.2	17.9%
3	Борлуулах цахилгаан эрчим хүч		сая.кВтц	1,139.8	1,186.2	1,209.1	22.9	1.9%
4	Нийт орлого		сая.төг	255,834.8	261,939.1	269,870.8	7,931.7	3.0%
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	232,268.8	239,604.6	245,566.5	5,962.0	2.5%
		Түгээх үйлчилгээний орлого	сая.төг	22,694.4	21,687.9	23,830.4	2,142.5	9.9%
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	871.6	646.6	473.9	-172.7	-26.7%
5	Нийт зардал		сая.төг	256,947.4	264,337.0	270,572.9	6,235.9	2.4%
	Үүнээс:	Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	сая.төг	229,922.5	236,896.2	242,967.1	6,070.8	2.6%
		Үйл ажиллагааны зардал	сая.төг	25,970.2	26,264.6	27,204.6	940.0	3.6%
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	557.2	646.6	400.8	-245.8	-38.0%
		Валютын ханшийн бодит бус алдагдал	сая.төг	497.4	529.6	0.4	-529.2	-99.9%
6	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая.төг	-1,112.6	-2,398.0	-702.1	1,695.8	-70.7%
7	Татварын дараах ашиг /алдагдал/		сая.төг	-1,118.6	-2,398.0	-898.4	1,499.5	-62.5%
8	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төгрөг	1.00	1.01	1.00	-0.01	-0.6%
9	Нийт авлага		сая.төг	15,565.3	12,545.9	23,643.5	11,097.6	88.5%
	Үүнээс:	ЦЭХ-ний	сая.төг	15,271.3	12,432.6	23,523.5	11,090.9	89.2%
		Бусад	сая.төг	294.0	113.3	120.0	6.7	5.9%
10	Нийт өглөг		сая.төг	36,320.3	58,752.3	52,320.0	-6,432.3	-10.9%
	Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая.төг	14,423.3	13,708.5	22,137.0	8,428.5	61.5%
		Урт хугацаат өр төлбөр	сая.төг	21,897.0	45,043.8	30,183.0	14,860.8	-33.0%
11	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ		сая.төг	4,576.0	5,487.7	4,582.5	-905.2	-16.5%
12	Нийт ажиллагсдын тоо		хүн	658	658	658	0.0	0.0%
13	Нийт цалингийн сан		сая.төг	10,852.6	11,165.1	10,998.6	-166.5	-1.5%

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад насжилт өндөртэй бараа материалыг эргэлтэд оруулж хөрөнгийг үр ашигтай зарцуулах, цалин хөлсийг татвар нийгмийн даатгалын тайланд зөрүүгүй тайлагнах, гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт зорилтот бүлэгт үзүүлэх, үлдэгдлийг баталгаажуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Цогзолмаа, О.Цэндхүү, аудитор М.Батмагнай, аудиторов туслах Э.Ундрах-Эрдэнэ, С.Номин, Б.Болорчимэг, Т.Алтанчимэг, Б.Амаржаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг нар тус тус хэрэгжүүлсэн.

“Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Мишээл-Од Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/86 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрчим хүчний яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас цахилгаан эрчим хүчний хөнгөлөлттэй холбоотой шалгалт хийж, ерөнхий чиглэл өгч ажилласан.

Дотоод аудитор тайлант онд нийт 30 төрлийн хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс 93.0 хувийн хэрэгжилттэй, нэмэлтээр төлөвлөгөөт бус 2 төрлийн хяналт шалгалтыг хийж, тухай бүрд зөвлөмж, албан шаардлага хүргүүлж, биелэлтийг гаргуулан ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 255,834.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,558.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн зорилго нь “Найдвартай, чанартай цахилгаан эрчим хүчийг түгээхдээ хэрэглэгчээ хүндэлж, нийгмийн хариуцлагыг эрхэмлэн, аюулгүй ажиллагааг ханган ажиллах”-д оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахилгаан эрчим хүч түгээх, борлуулах, ЦЭХ-ээр зохицуулалттай болон зохицуулалтгүй хангах
- Цахилгаан эрчим хүчний шугамын болон тоног төхөөрөмжийн угсралт, засвар

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хувьцаат компани статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 70.0 хувь, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 30.0 хувийг эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК нь Сайд нарын зөвлөлийн 1980 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 377 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчид томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүний нэрийг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгох ...” гэсэн заалттай нийцэж байна.

"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сарын цалин, урамшууллыг 0.7 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд эд хөрөнгийн хяналт тооллогыг зохион байгуулж, хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой шийдвэрүүдийг цаг тухайд нь хэрэгжүүлсэн, төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэхэд зөрчилтэй байсан 54 газар эзэмших эрхийн зөрчлийг бүрэн арилгаж бүртгэлд тусгах арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу ТУЗ-ийн 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн тогтоолоор компанийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж, 1 хэлтэс шинээр нэмэгдсэн боловч орон тоог нэмэгдүүлэлгүйгээр зохион байгуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- ЗГ-ын 2021 оны 207 дугаар тогтоол “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай”
- ЭБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны А/146 тоот тушаал “Цахилгаан эрчим хүчний төлбөрийг тооцох аргачлал”
- ЭБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны А/241 тоот тушаал “Цахилгаан эрчим хүчний төлбөрийг тооцох аргачлалд өөрчлөлт оруулах тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,355,014.4	1,483,954.1	128,939.7
Авлага	15,565,267.2	23,643,541.2	8,078,274.3
Урьдчилгаа	2,320,694.3	2,889,749.2	569,054.9
Бараа материал	2,271,797.6	3,808,700.3	1,536,902.7
Үндсэн хөрөнгө	134,835,372.9	141,031,049.0	6,195,676.1
Биет бус хөрөнгө	3,017,491.8	2,989,749.2	-27,742.6
Нийт хөрөнгийн дүн	159,365,638.2	175,846,946.3	16,481,308.1
Өр төлбөрийн дүн	36,320,280.7	52,320,003.9	15,999,723.2
Богино хугацаат өглөг	14,423,316.3	22,137,042.1	7,713,725.8
Урт хугацаат өглөг	21,896,964.4	30,182,961.8	8,285,997.4
Эздийн өмч	127,441,136.0	133,704,869.8	6,263,733.8
Хуримтлагдсан ашиг	-4,395,778.5	-10,177,927.4	-5,782,148.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	159,365,638.2	175,846,946.3	16,481,308.1

Касс дахь бэлэн мөнгө 3.5 сая, банк дахь харилцах дансанд 1,462.6 сая төгрөг, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөд 17.8 сая төгрөгийн шатахууны картын үлдэгдэл байна.

Авлагын үлдэгдэлд цахилгаан эрчим хүчний авлага 23,523.5 сая, татвар, НДШ-ийн авлага 91.5 сая төгрөг, бусад авлага 28.5 сая төгрөг байна.

Тайлант онд цахилгаан эрчим хүчний төлбөрийн хүрээнд үүссэн хэрэглэгчээс авах авлага 5,985.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 23,629.1 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 14.4 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагын нөөц сан байгуулаагүй. Тайлант онд 132.6 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөц байгуулж, (үйл ажиллагааны бус зардлын төлөвлөгөөнд тусгасан) шийдвэрээр 132.5 сая төгрөгийн найдваргүй авлагыг данснаас хассан байна.

Тайлант онд Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа ЭХТ-2 төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй Санхүү, Хүний нөөцийн ERP системийн урьдчилгаанд 88.6 сая төгрөг, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардал 231.4 сая төгрөг, зээлийн хуримтлагдсан хүүд 526.0 сая төгрөг тооцож, урьдчилгаа шилжүүлсэн байна.

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 оноос өмнө шилжүүлсэн 2,298.9 сая төгрөгийн ЭХТ-2 төслийн хөрөнгө оруулалт болон зардлыг төслийн хэрэгжилт дуусаагүй байгаа тул гүйцэтгэлийг хүлээн авч, хөрөнгөөр тусгаагүй байна. Урьдчилгаа данснаас тайлант онд ажлын гүйцэтгэлийг дүгнэн, акт үйлдэж 108.8 сая төгрөгийн хүүгийн төлбөрийг Эрдэнэт 35/6 кВ-ын дэд станцын өртөгт тооцон, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,808.7 сая төгрөг болж 1,536.9 сая төгрөгөөр өссөн нь аваарын нөөцийн 1,460.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материал ангилалд шилжүүлэн бүртгэсэн, Ковид-19 цар тахлын улмаас импортын барааны ачаа тээврийн хугацаа удааширнаас оны төгсгөлд бараа материал нийлүүлэгдсэнээс цахилгаан сэлбэг хэрэгсэл 52.5 сая төгрөг, аваарын нөөцийн хөрөнгө 185.1 сая төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 4,681.4 сая төгрөгөөр бараа материал нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй, олон жил болсон 308.5 сая төгрөгийн бараа материал байна. Энэ нь 3-5 жил болсон, компанийн үйл ажиллагаанд ашиглагдах боловч, эргэлт удаантай цахилгааны сэлбэг хэрэгсэл байна.

Оны эцэст 237.6 сая төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь Ковид-19 цар тахлын улмаас импортын барааны ачаа тээврийн хугацаа удааширнаас оны төгсгөлд бараа материал нийлүүлэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 4,413.8 сая, үнэлгээг шинэчлэн тогтоосон 40.0 сая, дуусаагүй барилгад нэмэгдсэн болон их засварын капиталжуулсан зардал 3,169.3 сая, ШШГЕГ-ын 439 дүгээр хаалттай хорих ангиас балансаас баланст үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 63.0 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2021 оны 207 дугаар тогтоолоор худалдан борлуулсан 19.5 сая, А-1/682 дугаар албан бичиг, 583 дугаар тогтоолоор акталсан 164.5 сая, 67 дугаар тогтоолоор балансаас баланст Алтай Улиастай эрчим хүчний систем ТӨХК-д шилжүүлсэн 75.4 сая, хөрөнгийн ангилал хооронд залруулсан 1,460.0 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 27.7 сая төгрөгийн хасагдуулгын дүнгээр буурчээ.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл 16,310.6 сая төгрөг болж, өмнөх оноос 6,629.9 сая төгрөгөөр өссөн байна. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа ЭХТ-2 төслийн хүрээнд эхэлсэн Орхон, Өвөрхангай, Хархорины 6/0,4 кВ-ын цахилгаан хангамжийн ажлууд 8,491.6 сая, Орхон ХҮТ-ийн барилга 513.9 сая, компанийн их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу баригдаж буй 4 ажлын өртөг 274.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, дууссан 3,169.3 сая төгрөгийн ажлын Эрдэнэт 35/6 кВ-ын дэд станцыг үндсэн хөрөнгөнд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгөнд 980.1 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө болон хувь тэнцүүлсэн НӨАТ-ын авлага бүртгэсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 22,137.0 сая төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 30,183 сая төгрөг байгаа ба тайлант онд 8,286.0 сая төгрөгөөр нэмэгдсэн. 2018 оноос хэрэгжиж байгаа ЭХТ-2 төслийн дамжуулан зээлдүүлэх зээлийн дүн 21,196.3 сая төгрөг, зээлийн үндсэн төлбөр 2023 оноос төлөгдөж эхэлнэ. 2003 онд үүссэн ЭХТ-1 төслийн зээл 31.1 сая төгрөг бөгөөд 2021 онд төлсөн дүн 1.6 сая төгрөг, зээлийн хугацаа хэтрээгүй, хэвийн байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт худалдан авсан цахилгаан эрчим хүчний өртөг болон түгээх үйл ажиллагааны зардлуудыг хамруулсан байна. Эрчим хүчний салбарын компаниудын НБББББ-т заасан нь зөрчигдөөгүй байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний Сайдын 2021 оны А/14 дүгээр тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 261,939.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 264,337.0 сая төгрөгөөр, 2,398.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 5,681.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 269,870.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 270,572.9 сая төгрөгийн зардал гарган, 702.1 сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 269,870.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 7,931.7 сая төгрөг буюу 3.0 хувиар давсан, үүнээс цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого 5,962.0 сая төгрөг буюу 2.5 хувиар, түгээх үйл ажиллагааны орлого 2,142.5 сая төгрөг буюу 9.9 хувиар өссөн зэрэг нь нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 270,572.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 6,235.9 сая төгрөг буюу 2.4 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь ХАЦЭХ-ийн өртөг, борлуулалт өссөнөөс 6,070.8 сая төгрөгөөр, үйл ажиллагааны зардал 940.0 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 88 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 4,582.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 702.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,695.8 сая төгрөгөөр илүү байгаа нь нийт орлого 3.0 хувиар, нийт зардал 2.4 хувиар өссөнөөс нөлөөлж байна.

ТӨБЗГ-т өмнөх онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилж, төвлөрүүлээгүй ба түрээсийн орлогын 40.0 хувь буюу 8.6 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК нь тайлант онд нийт 563,647.4 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах ёстойг хуулийн хугацаанд нь иж бүрэн байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Оны тэргүүний ажилтнуудыг шалгаруулан 23.5 сая төгрөгийн шагнал урамшуулал олгосон, шинэ жилийн баяр ёслолын арга хэмжээнд 13.2 сая төгрөгийг зарцуулсан. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын 1.3. "...цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх", 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг мөрдөж ажиллах, засгийн газрын тогтоолын дагуу хэмнэлт гаргах албан шаардлага хүргүүлэх

ЭХЗХ-ны 2017 оны 199 дүгээр тоот тогтоолоор "Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифийн хөнгөлөлт үзүүлэх журам"-ын дагуу Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг хөнгөлж, эх үүсвэр нь ЭХЯ-аар дамжин БОАЖЯ-ны агаарын бохирдлыг бууруулах сангаас төлөгддөг бөгөөд оны эцсийн байдлаар 519.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд тус үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, тулган баталгаажуулалтын захидал хүргүүлсэн боловч хариугаар баталгаажихгүй байна. Тус хөнгөлөлтийн зорилго хангалтгүй хөнгөлөлт эдлэх шаардлагатай хэрэглэгчид хөнгөлөлтийг эдлэх боломж хязгаарлагдмал, эх үүсвэр хүрэлцэхгүй их хэмжээний авлагатай байхад хөнгөлөлтийн ихэнх хувийг төлбөрийн чадвартай иргэд эдэлсэн, утааг их хэмжээгээр үйлдвэрлэж буй ихэнх хэрэглэгч амьдардаг гэр хорооллын иргэд цахилгаанаар дулаанаа шийдэх боломжгүй байгаагаас утаа буурахгүй байгаа байдалд судалгаа, шинжилгээ хийгдээгүй, төлөх эх үүсвэр хангалтгүй байхад хөнгөлөлтийг их хэмжээгээр эдлүүлж авлагын дүнг өсгөсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөнгөлөлт олгох журмыг дахин нягталж, дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд журамд шинэчлэлт өөрчлөлт оруулах, авлагыг барагдуулах, эх үүсвэрийг тодорхой болгож тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, зөвлөмж хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ажилтнуудад шагнал урамшуулал олгож, баяр ёслолын зардал гаргасан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 802.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 196.2 сая төгрөгийг залруулж, 1.8 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 604.8 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 458.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1,045.3 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснөөс албан шаардлага 90.0 хувь, зөвлөмж 93.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	458.8	2	458.8			90.0
Зөвлөмж	5	1,045.3	5	1,045.3			93.0
Нийт дүн	7	1,504.1	7	1,504.1			91.5

/мянган төгрөг/

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд одоо ашиглаж буй санхүүгийн программыг сольж, Интер-Актив ХХК-ийн “Veritech ERP” программыг шинээр нэвтрүүлж эхэлсэн байна. Тайлант онд программын нэвтрүүлэлтийн ажил хийгдэж, сургалт зохион байгуулж, туршилт хийсэн бөгөөд 2022 оноос тус программыг бүрэн ашиглалтад оруулж санхүүгийн тайланг шинэ программаар бэлтгэн гаргаж байгаа тул санхүүгийн бүртгэл хөтлөлт үнэн зөв, иж бүрэн, алдаагүй бүртгэгдэж байгаа эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,997.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 198.1 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 8.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,353.2 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 312.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж, 125.0 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэв. Тус компанийн өмчлөлийн 125.0 сая төгрөгийн анхны өртөгтэй 10 ширхэг зуслангийн байшинг тус компанийн зөвшөөрөлгүйгээр өөр хуулийн этгээд амралтын газрын зориулалтаар ашигласныг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэв.

Залруулагдаагүй 1,709.1 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 2,558.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 198.1 сая төгрөгийн 6 алдааг залрууллаа. Үүнд:

- НББОУС-16 Үндсэн хөрөнгө стандартын 67 “Үндсэн хөрөнгийн зүйлийн дансны үнийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө б. Хөрөнгийн ашиглалт буюу данснаас хасалтаар хүлээгдэж буй ирээдүйн эдийн засгийн үр өгөөжгүй болсон” гэсэн заалттай нийцүүлээгүй, сумдад байрлалтай 2 болон 4 айлын орон сууцуудын ашиглалт хангалтгүй, зарим орон сууцанд хүн амьдардаггүй, буюу үйл ажиллагаанд ашиглагдахгүй компанид үр өгөөжөө өгөхгүй байгаа хөрөнгө бүртгэлтэй, элэгдлийн зардлыг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- НББОУС-12 Орлогын албан татвар стандартын 12 “Тухайн тайлант болон өмнөх тайлант хугацаанд хамаарах тайлант үеийн татварыг түүний төлөгдөөгүй байгаа дүнгээр өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө” гэсэн заалттай нийцүүлээгүй,

хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөрийг зөрүүтэй тооцсоноос орлогын татварын зардал 196.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;

- Хүүхдээ асарч буй чөлөөт эхэд олгох тэтгэмжийг 0.3 сая төгрөгөөр илүү олгосон. Нийгмийн даатгалын тайланд 1.5 сая төгрөгийн цалин хөлсийг илүү тайлагнасан.
- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлд тооцсон элэгдлийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хасагдах зардлаар тайлагнасан;
- Шатахууны нормыг бодит байдлаас зөрүүтэйгээр тогтоосон;
- Эмзэг бүлгийн өрхөд цахилгааны хөнгөлөлт үзүүлэхдээ хөнгөлөлтөд хамрагдсан айл өрхүүдийг тодорхой хугацаанд эргэн шалгаагүй, хөнгөлөлтөд хамрагдах шаардлагагүй төлбөрийн чадвартай айл өрхүүд хөнгөлөлтөд хамрагдсан, мөн зарим салбар нь эмзэг бүлгийн өрхүүдийг огт хөнгөлөлтөд хамруулаагүй.

8.2 Төлбөрийн акт

НӨАТ төлөгч бус компанитай НӨАТ-тэй дүнгээр гэрээ байгуулснаас 6 харилцагчид 8.0 сая төгрөгийн НӨАТ-ын татварын илүү шилжүүлсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 "Тендерийн баримт бичигт өөрөөр заагаагүй бол тендерийн үнэд татвар, даатгал, тээвэрлэлтийн болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бусад бүх зардлыг багтааж тооцох бөгөөд эдгээр зардлыг тендерийн үнэд тусгайлан тооцоогүй бол захиалагч тухайн зардлыг тендерийн үнэд багтсан гэж үзнэ" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

8.3 Албан шаардлага

Нээлттэй тендер шалгаруулалтын аргааг зохион байгуулах 114.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж худалдан авалт хийсэн. Энэ нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Шинэ кран худалдан авахаар 250.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, барааг хүлээн авсан боловч техникийн нөхцөлийг гэрээний хавсралтаар оруулаагүй, бараа хүлээн авах комисс хариуцлагагүй ажилласнаас компанид хуучин кран хүлээлгэн өгч хохирол учруулсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д "Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна: ... 46.1.4 "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Үнэлгээний хороо нь 1 төсөл арга хэмжээний 106.5 сая төгрөгийн тендер шалгаруулалтад үнэлгээ хийхдээ тендерийн баримт бичигт заасан шаардлагад нийцсэн оролцогчийг шалгаруулахгүйгээр татгалзаж тендер шалгаруулалтын үнэлгээг буруу хийсэн. Нэг төрлийн бараа худалдан авах тендер шалгаруулалтыг тодотголоор дахин зохион байгуулахдаа 7 сарын өмнө худалдан авсан үнээс 36.0 хувиар буюу 18.3 сая төгрөгөөр илүү үнээр төсөвт өртгийг тооцож өндөр үнээр худалдан авалт хийсэн, төсөвт өртгийг хэрхэн тодорхойлсон нь тодорхойгүй байна. Мөн 6 төсөл арга хэмжээний 814.4 сая төгрөгийн бараа нийлүүлэх гэрээний хугацааг сунгах үндэслэл, нотлох баримт хангалтгүй байхад удаа дараа сунгаж, алданги тооцоогүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11-д "Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлж «хамгийн сайн» үнэлэгдсэн тендерийг шалгаруулахад шалгуур үзүүлэлтүүдийг тендерийн баримт бичигт заасан журмын дагуу ашиглана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Овоолго шороог ашиглан катодын зэсийн үйлдвэр барихаар нуруулдан уусгах талбай болон гадна шугам хоолойн угсралт, суурилуулалт, уурын зуухны барилга барих зэрэг бүтээн байгуулалт хийж байгаа компанийг уул уурхайн чиглэлийн ангиллаас арилжааны байгууллагын ангилал руу шилжүүлэн бүртгэж, 32.3 сая төгрөгийн Засгийн газрын хөнгөлөлт эдлүүлсэн үндэслэлийн баримтын бүрдэл хангалтгүй байна. Энэ нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан "Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1 "Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх..." 1.3 "Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн байраар ашиглаж байсан 16.9 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилгыг үйл ажиллагаанд ашиглаагүй, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч компанийн багаж, ажлыг хэрэгслийг түр байрлуулсан, төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай ашиглахгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-д "Төрийн өмчийн төлөөлөгч дараах эрх үүрэгтэй: төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах .." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Үйл ажиллагаанд ашиглахгүй удсан, насжилт өндөртэй 308.5 сая төгрөгийн бараа материалыг үр ашигтай ашиглах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 "Төрийн өмчийн төлөөлөгч дараах эрх үүрэгтэй: төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Насжилт өндөртэй бараа материалыг эргэлтэд оруулж, үйл ажиллагаанд ашиглах, хөрөнгийг үр ашигтай зарцуулах арга хэмжээ авч ажиллах

2. Цалингийн зардал холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 2.5 сая төгрөг, нийгмийн даатгалын тайланд 1.9 сая төгрөгийн цалин хөлсийг тус тус илүү тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4 "үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

АХГ-2022/96/НА-СТА-ТӨА

Татвар нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан цалин хөлсний дүнг залруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс											
							Загруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		Хуулийн байгууллагад шилжүүлэх	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																		
1	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	Шатахууны нормыг бодит байдлаас зөрүүтэйгээр тогтоосон	Шатахууны нормыг бодит байдалтай уялдуулан шинэчлэн тогтоох	1		1											
2	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	Сумдад байрлалтай 2 болон 4 айлын орон сууцуудын ашиглалт хангалтгүй, зарим орон сууцанд хүн амьдардаггүй, буюу үйл ажиллагаанд ашиглагдахгүй компанид үр өгөөжөө өгөхгүй байгаа хөрөнгө бүртгэлтэй, элэгдлийн зардал байгуулагдсан	Үйл ажиллагаанд ашиглахгүй хөрөнгийг ашиглалтад оруулах, хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах	1		1											
3	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	Хүүхдээ асарч буй чөлөөт эхэд олгох тэтгэмжийг 300.0 мянган төгрөгөөр илүү олгосон. Нийгмийн даатгалын тайланд 1,500.0 мянган төгрөгийн цалин хөлсийг илүү тайлагнасан.	Илүү олгосон тэтгэмжийг буцаан төлөх, нийгмийн даатгалын тайланд залруулга хийх	1	1,800.0	1	1,800.0										
4	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлд тооцсон элэгдлийг тусад нь тооцоолж гаргаагүйгээс ААНОАТ-д хасагдах зардлаар тайлагнасан.	Дахин үнэлгээний нэмэгдэлд тооцсон элэгдлийг хасагдахгүй зардлаар тооцох	1		1											

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/9 6/НА-СТА-ТӨА	Хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөрийг зөрүүтэй тооцсоноос орлогын татварын зардал 196,256.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн	Хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөрийг тооцож бүртгэх	1	196,256.4	1	196,256.4										
6	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/9 6/НА-СТА-ТӨА	Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 106 дугаар тогтоолын дагуу эмзэг бүлгийн өрхөд цахилгааны хөнгөлөлт үзүүлэхдээ хөнгөлөлтөд хамрагдсан айл өрхүүдийг тодорхой хугацаанд эргэн шалгадаггүйгээс хөнгөлөлтөд хамрагдах шаардлагагүй төлбөрийн чадвартай айл өрхүүд хөнгөлөлтөд хамрагдсан байдалтай байна. Мөн зарим салбар нь эмзэг бүлгийн өрхүүдийг хөнгөлөлтөд үзүүлдэггүй буюу тус тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.	Тогтоолын дагуу хөнгөлөлтөд хамрагдаж буй иргэдийг дахин үнэлэх, тогтоолыг хэрэгжүүлж ажиллах	1		1											
7	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/9 6/НА-СТА-ТӨА	Үйл ажиллагаанд ашиглахгүй удсан, насжилт өндөртэй 308,425.0 мянган төгрөгийн бараа материалыг үр ашигтай ашиглах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна	Насжилт өндөртэй бараа материалыг эргэлтэд оруулж, хөрөнгийг үр ашигтай зарцуулах	1	308,425.0							1	308,425.0				
8	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/9 6/НА-СТА-ТӨА	Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн байраар ашиглаж байсан 16,973.6 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилгыг үйл ажиллагаанд ашиглаагүй, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч компанийн багаж, ажлыг хэрэгслийг түр байрлуулсан, төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүй байна.	Үйл ажиллагаанд ашиглагдаагүй сул чөлөөтэй хөрөнгийг түрээслэх эсхүл шаардлагатай байгууллага руу шилжүүлэн өгөх	1	16,973.6		1	16,973.6									
9	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/9 6/НА-СТА-ТӨА	Тус компанийн өмчлөлийн Бөхөнгийн зусланд байрлах 10 ширхэг нийт 125,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой зуслангийн байшинг тус компанийн зөвшөөрөлгүйгээр өөр хуулийн этгээд амралтын газрын зориулалтаар ашигласныг аудитаар илрүүлж, завсрын аудитаар орлогыг тооцон гаргуулан авах зөвлөмж өгсөн боловч түрээсийн орлого авах талаар ажиллаагүй.	Амралтын газрын зориулалтаар ашиглаж олсон орлогыг гаргуулан авах, хөрөнгөд тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах	1	125,000.0									1	125,000.0		

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

10	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 2,518.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын тайланд 1,938.2 мянган төгрөгийн цалин хөлсийг тус тус илүү тайлагнасан	Цалин хөлсийг татвар, нийгмийн даатгалын тайланд зөрүүгүй тайлагнах	1	4,456.4									1	4,456.4		
11	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	НӨАТ төлөгч бус компанитай НӨАТ-тэй дүнгээр гэрээ байгуулснаас 6 харилцагчид 8,047.1 мянган төгрөгийн НӨАТ-ын татварын илүү шилжүүлсэн.	Илүү шилжүүлсэн НӨАТ-ын татварыг буцаан авч, төлбөрийг барагдуулах	1	8,047.1				1	8,047.1							
12	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	Овоолго шороог ашиглан катодын ээсийн үйлдвэр барихаар нуруулдан уусгах талбай болон гадна шугам хоолойн угсралт, суурилуулалт, уурын зуухны барилга барих зэрэг бүтээн байгуулалт хийж байгаа компанийг уул уурхайн чиглэлийн ангиллаас арилжааны байгууллагын ангилал руу шилжүүлэн бүртгэхдээ үндэслэлсэн баримтын бүрдэл хангалтгүйгээр 32,341.0 мянган төгрөгийн засгийн газрын хөнгөлөлт эдлүүлсэн.	Хөнгөлөлт эдлүүлэх ангиллыг солихдоо нотлох баримтыг хангалттай бүрдүүлэх	1	32,341.0				1	32,341.0							
13	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	Нээлттэй тендер шалгаруулалтын журам мөрдөгдөх 114,716.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа төсөл арга хэмжээний төсөвт өртгийг хуваахгүй байх	1	114,716.0				1	114,716.0							

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

14	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	Шинэ кран худалдан авахаар 250,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж барааг хүлээн авсан акт үйлдсэн. Гэрээ дүгнэх явцад хуучин кран нийлүүлсэн, гаалийн мэдүүлгийг хуурамчаар үйлдсэнийг тус компани мэдээд бэлтгэн нийлүүлэгчийг шүүхэд өгсөн боловч техникийн нөхцлийг гэрээний хавсралтаар оруулаагүй, бараа хүлээн авах комисс хариуцлагагүй ажиллаж барааг хүлээн авсантай холбоотойгоор шүүх бэлтгэн нийлүүлэгчийн талд шийдвэр гаргаж төлбөрийг шүүхийн шийдвэрээр харилцах данснаас гаргуулан авч, компанид хохирол учруулсан. Мөн бараа хүлээн авах комиссын гишүүн хуучин кран байсныг мэдсэн боловч нуун дарагдуулж барааг хүлээн авсан.	Бэлтгэн нийлүүлэгчээс хохирлыг барагдуулан авах	1	250,000.0					1	250,000.0						
15	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	Тендерийн баримт бичигт заасан шаардлагад нийцсэн оролцогчийг үндэслэлгүй шалтгаанаар шалгаруулаагүй, 1 төсөл арга хэмжээний 106,500.0 мянган төгрөгийн тендер шалгаруулалтын үнэлгээг буруу хийсэн. Мөн нэг төрлийн барааны тендер шалгаруулалтыг тодотголоор дахин зохион байгуулахдаа 7 сарын өмнө худалдан авсан үнээс 36 хувиар буюу 18,293.0 мянган төгрөгөөр илүү үнээр төсөвт өртгийг тооцож худалдан авалт хийсэн төсөвт өртгийг хэрхэн тооцсон нь тодорхойгүй, зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авалт хийсэн, худалдан авах ажиллагааны тендерийн баримт бичиг болон гэрээнд тусгагдсан хугацааг нэг болон хэд хэдэн удаа сунгасан мөн зарим гэрээ нь сунгагдаагүй боловч гэрээний хугацаа дууссан байдалтай нийт 6 төсөл арга хэмжээний, 814,357.5 мянган төгрөгийн худалдан авалт удааширсан, гэрээ сунгахад үндэслэсэн нотлох баримт хангалтгүй байна.	Тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт бүрээр үнэлгээг үнэн зөв хийх	1	939,150.5					1	939,150.5						
ДҮН					15	1,997,166.0	6	198,056.4	1	8,047.1	5	1,353,181.1	0	0	2	312,881.4	1	125,000.0

Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																		
2	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	Оны тэргүүний ажилтнуудыг шалгаруулан шилдэг ажилтнуудад 23,500.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон, шинэ жилийн баяр ёслолын арга хэмжээнд 13,200.0 мянган төгрөгийг зарцуулсан.	Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолыг мөрдөж ажиллан, тэвчиж болох бүх зардлыг тэвчиж, зардлыг хэмнэх, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	36,700.0												
5	"Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	АХГ-2022/96/НА-СТА-ТӨА	ЭХЗХ-ны 2017 оны 199 дүгээр тоот тогтоолоор "Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифийн хөнгөлөлт үзүүлэх журам"-ын дагуу Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг хөнгөлж, эх үүсвэр нь ЭХЯ-аар дамжин БОАЖЯ-ны агаарын бохирдлыг бууруулах сангаас төлөгддөг бөгөөд оны эцсийн байдлаар 519,776.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд тус үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, тулган баталгаажуулалтын захидал хүргүүлсэн боловч хариугаар баталгаажихгүй байна. Тус хөнгөлөлтийн зорилго хангалтгүй хөнгөлөлт эдлэх шаардлагатай хэрэглэгчид хөнгөлөлтийг эдлэх боломж хязгаарлагдмал, эх үүсвэр хүрэлцэхгүй их хэмжээний авлагатай байхад хөнгөлөлтийн ихэнх хувийг төлбөрийн чадвартай иргэд эдэлсэн, утааг их хэмжээгээр үйлдвэрлэж буй ихэнх хэрэглэгч амьдардаг гэр хорооллын иргэд цахилгаанаар дулаанаа шийдэх боломжгүй байгаагаас утаа буурахгүй байгаа байдалд судалгаа, шинжилгээ хийгдээгүй, төлөх эх үүсвэр хангалтгүй байхад хөнгөлөлтийг их хэмжээгээр эдлүүлж авлагын дүнг өсгөсөн байна.	Хөнгөлөлт олгох журмыг дахин нягталж, дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд журамд шинэчлэлт өөрчлөлт оруулах, авлагыг барагдуулах, эх үүсвэрийг тодорхой болгох	1										1			
			Дүн		2	36,700.0	0	0	0	0	1	36,700.0	0	0	1	0	0	0
НИЙТ ДҮН					17	2,033,866.0	6	198,056.4	1	8,047.1	6	1,389,881.1	0	0	3	312,881.4	1	125,000.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 444/20150055
АХГ-2022/86/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үнэлгээний хороо нь 1 төсөл, арга хэмжээний 106,500,000.00 төгрөгийн тендер шалгаруулалтад үнэлгээ хийхдээ тендерийн баримт бичигт заасан шаардлагад нийцсэн оролцогчийг шалгаруулахгүйгээр татгалзаж, тендер шалгаруулалтын үнэлгээг буруу хийсэн. Нэг төрлийн бараа худалдан авах тендер шалгаруулалтыг тодотголоор дахин зохион байгуулахдаа 7 сарын өмнө худалдан авсан үнээс 36.0 хувиар буюу 18,293,000.00 төгрөгөөр илүү үнээр төсөвт өртгийг тооцож, өндөр үнээр худалдан авалт хийсэн, төсөвт өртгийг хэрхэн тодорхойлсон нь тодорхойгүй байна. Мөн 6 төсөл, арга хэмжээний 814,357,476.00 төгрөгийн бараа нийлүүлэх гэрээний хугацааг сунгах үндэслэл, нотлох баримт хангалтгүй байхад удаа дараа сунгаж, алданги тооцоогүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11 "Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлж, «хамгийн сайн» үнэлэгдсэн тендерийг шалгаруулахад шалгуур үзүүлэлтүүдийг тендерийн баримт бичигт заасан журмын дагуу ашиглана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үнэлгээний хороо тендерийн баримт бичигт заасны дагуу үнэлгээг үнэн зөв хийх, төсөвт өртгийг батлахдаа үнийн судалгаа хийх, гэрээний хугацааг сунгахдаа нотлох баримтыг үндэслэх, хууль, журмын дагуу худалдан авалтыг хийж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал В.Адъяа, нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\03\5 Auditin 2 Gazar-116.Docx

0010801022



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 441/20150055
АХГ-2022/36/НА-СТАТОН

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн байрны зориулалтаар ашиглаж байсан 16,973,581.17 төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилгыг үйл ажиллагаанд ашиглаагүй, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч компанийн багаж, ажлын хэрэгслийг түр байрлуулсан, төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай зориулалтын дагуу ашиглахгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 "Төрийн өмчийн төлөөлөгч дараах эрх үүрэгтэй: төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж, төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үйл ажиллагаанд ашиглаагүй сул чөлөөтэй хөрөнгийг үр ашигтай ашиглан, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал В.Адъяа, нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 443/00150055
АХГ-2022/96/МАН СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Овоолго шороог ашиглан катодын зэсийн үйлдвэр барихаар нуруулдан уусгах талбай болон гадна шугам хоолойн угсралт, суурилуулалт, уурын зуухны барилга барих зэрэг бүтээн байгуулалт хийж байгаа компанийг уул уурхайн чиглэлийн ангиллаас арилжааны байгууллагын ангилал руу шилжүүлэн бүртгэж, 32,341,044.61 төгрөгийн хөнгөлөлт эдлүүлсэн үндэслэлийн баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1 "Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх...", 1.3 "Уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр" гэсэн заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хэрэглэгчийн ангиллыг үнэн зөв бүртгэсэн эсэхийг нотлох баримттай тулгаж, баримтын бүрдлийг хангаж, буруу бүртгэсэн ангиллыг залруулан, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал В.Адъяа, нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

10.10.10.20-Bichig_Kherug-Alban-Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-117.Docx

0010801024



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 442/А0150055

Улаанбаатар хот

АХГ-0002/36/рА-СТАТБА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинэ кран худалдан авах 250,000,000.00 төгрөгийн гэрээ байгуулахдаа техникийн нөхцөлийг гэрээний хавсралтаар оруулаагүй, бараа хүлээн авах комисс хариуцлагагүй ажилласнаас компанид хуучин кран хүлээлгэн өгч хохирол учруулсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 "Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна" 46.1.4 "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бэлтгэн нийлүүлэгчээс компанид учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээ авч, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал В.Адъяа, нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-115.Docx

0010801220



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 440/20220055

Улаанбаатар хот

АХГ-2022/36/НА-СТА ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулах 114,716,000.00 төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж худалдан авалт хийсэн.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа ижил төстэй төсөл арга хэмжээг хуваахгүй байх, худалдан авах ажиллагааны аргыг зөв сонгон, зохион байгуулж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал В.Адъяа, нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 439/АД/СОДСС
АХГ-2022/36/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Оны тэргүүний ажилтнуудыг шалгаруулан 23,500,000.00 төгрөгийн шагнал урамшуулал олгосон, шинэ жилийн баяр ёслолын арга хэмжээнд 13,230,352.00 төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3. "...цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх", 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг мөрдөж ажиллах, Засгийн газрын тогтоолын дагуу хэмнэлттэй ажиллан, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал В.Адъяа, нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРД ДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Т.ОДОНЧИМЭГ

0010801014



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 34/АО/50055

Улаанбаатар хот

АХГ-0022/96/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

НӨАТ төлөгч бус компанитай НӨАТ-тэй дүнгээр гэрээ байгуулснаас 6 харилцагчид 8,047,118.00 төгрөгийн НӨАТ-ын татварыг илүү шилжүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6 "Тендерийн баримт бичигт өөрөөр заагаагүй бол тендерийн үнэд татвар, даатгал, тээвэрлэлтийн болон гэрээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах бусад бүх зардлыг багтааж тооцох бөгөөд эдгээр зардлыг тендерийн үнэд тусгайлан тооцоогүй бол захиалагч тухайн зардлыг тендерийн үнэд багтсан гэж үзнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Бэлтгэн нийлүүлэгчид илүү шилжүүлсэн 8,047,118.00 /найман сая дөчин долоон мянга нэг зуун арван найм/ төгрөгийг, холбогдох байгууллагуудаар төлүүлэн, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал В.Адъяа, нягтлан бодогч Б.Наранцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ:

Ц НАРАНЧИМЭГ
Ц ХОСЖАРГАЛ
Т ОДОНЧИМЭГ

9006109
9019120396

